



**Монголын Эмэгтэйчүүдийн Сан**

# “ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДАД”

## ЗОРИУЛАВ

## ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот  
2019 он



Санхүүгийн дэмжлэг үзүүлсэн Ази болон Номхон далайн бүсийн Яаралтай тусламжийн санд талархал илэрхийлье. Энэ гарын авлага нь санхүүжүүлэгчийн байр суурийг илэрхийлэхгүй

Монголын Эмэгтэйчүүдийн сан (МОНЭС)-гийн хүсэлтээр Хүний Эрх Хөгжил Төв (ХЭХТ) энэхүү Хүний эрхийн хамгаалагчийн гарын авлагыг боловсруулав.

## Өмнөх үг

Өөрийн болон бусдын хүний эрх, нийтийн эрх ашгийг хамгаалан “дуугарсан хүн” дарамт, шахалтанд орох болсон. Ийм тохиолдол орон нутагт элбэг гарч байна. Ялангуяа ашигт малтмалын хайгуул, олборлолтоос үүссэн байгаль орчин, ой, ус, бэлчээрийн нөөцөө хамгаалан дуугардаг иргэдийн хувьд эрсдэл илүү өндөр ажээ. Ийнхүү дуугарсан иргэний эсрэг нэр хоч өгөх, доромжлох, айлган сүрдүүлэх, зодох, гүтгэх, хуурамч хэрэг үүсгэх зэргээр дарамталж байна.

Иймээс хүний эрх, нийтийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааг дэмжих, ийм ажил хийдэг хүмүүс буюу “хүний эрхийн хамгаалагч (ХЭХ)-ийг” хамгаалах шаардлага байгааг анхаарч олон улсын хүний эрхийн хамгааллын механизмтай холбож байна. Үүнд НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчийн тунхаглал, НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчийн асуудлаарх Тусгай илтгэгч зэргийг дурдаж болно.

Бүс нутагт хүний эрхийн хамгаалагчдын уулзалт, хэлэлцүүлгүүд тогтмол зохион байгуулагдаж байна. Тухайлбал, Хүний эрх хөгжлийн төлөөх Азийн Форум хоёр жил тутам ХЭХ-дын бүсийн чуулганыг зохион байгуулж ХЭХ-дад зориулсан хөтөлбөр хэрэгжүүлэн үндэсний хэмжээнд хүний эрхийн хамгаалагчдын үйл ажиллагааг дэмжих, эрсдэлээс хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, тэдний хамтын ажиллагааг бэхжүүлэхэд тусалж байна. Энэ чиглэлээр Монголын хүний эрхийн олон байгууллагууд хамтран ажиллаж байна.

Хэдийгээр ХЭХ-чдыг хамгаалах арга хэмжээг үр дүнтэй болгох оролдлогыг үргэлжлүүлэн хийж байгаа боловч орон нутагт ХЭХ-чид төрийн бус этгээдийн халдах, доромжлох, заналхийлэх зэрэг үйлдэлд өртсөөр байгаа бөгөөд төрийн зүгээс хамгаалалт авч чадахгүй, үл тоомсорлох хандлага, зарим тохиолдолд дарамт, шахалт, ялгаварлан гадуурхалтад өртөж байна.

Иймд орон нутгийн иргэд, малчдад хүний эрх, ХЭХ-чийн талаарх ойлголт мэдлэг болон чадавхийг нэмэгдүүлэх, тэдэнд тулгарч болзошгүй эрсдлийг бууруулах, эрсдэлээс хамгаалах, орон нутгийн иргэдийг хамтран ажиллах чадавхийг бэхжүүлэх шаардлагатай.

Ийм учраас Монголын Эмэгтэйчүүдийн сан (МОНЭС)-гийн хүсэлтээр Хүний Эрх Хөгжил Төв (ХЭХТ) энэхүү Хүний эрхийн хамгаалагчийн гарын авлагыг боловсруулав.

## Агуулга

Өмнөх үг .....	3
Нэг: Хүний эрх гэж юу вэ? Хүний эрхийн хамгаалагч гэж хэн бэ? .....	5
Хоёр: Хүний эрхийн хамгаалагчид тулгардаг эрсдэл, түүний хэлбэр .....	12
Гурав: Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах нь .....	16
Дөрөв: Хүний эрхийн хамгаалагчдад өгөх зөвлөмж.....	22

# Нэг: Хүний эрх гэж юу вэ? Хүний эрхийн хамгаалагч гэж хэн бэ?

## *Хүний эрх гэж юу вэ?*

Хүний эрх гэдэг нь хүн бүр, хүн болж төрсний хувьд, ямар нэгэн ялгаатай байдлаас үл хамааран, айх аюул, гачигдах зовлонгүй хүний зэрэгтэй амьдрахад хэрэгтэй эрх, эрх чөлөө буюу хүн гэсэн нэр төрийн дор амьдрахад зайлшгүй шаардлагатай улс төр, эдийн засаг, нийгмийн нөхцөлийг бүрдүүлэх хэм хэмжээ юм.

Хүний эрх нь арьс өнгө, үндэс угсаа, хэл соёл, шашин шүтлэг, нийгмийн байдал, хөрөнгө.... зэргээс үл хамааран хүн бүрт төрөхөөс нь заяасан эрх, эрх чөлөө юм.

## Тухайлбал:

- Та амьд явах эрхтэй
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах,
- Сурч боловсрох, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох
- Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй.
- Эрүүл хүнсээр хангагдах эрхтэй
- Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, хамгаалуулах эрхтэй.
- Хүн бүр мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхтэй

## Хүний эрхийн зарчмууд:

Хүний эрх, эрх чөлөө нь түгээмэл

Түгээмэл байх зарчим нь олон улсын хүний эрхийн хуулийн цөм нь болдог. Улс орны Засгийн газрууд улс төр, эдийн засаг, соёлын системээс үл хамааран хүний эрх, эрх чөлөөг ханган, хамгаалах үүрэг хүлээдэг.

Хүний эрх, эрх чөлөө нь салшгүй

Хүний эрх, эрх чөлөө нь салшгүй. Хэн ч, хэний ч эрх, эрх чөлөөг авах, хураах, зогсоох эрхгүй.

Хүний эрх харилцан хамааралтай ба хуваагдашгүй.

Хүний эрх харилцан хамааралтай ба хуваагдашгүй. Хүний эрх иргэний улс төрийн эрх ч байна уу, эдийн засаг, нийгэм соёлын эрх ч байна уу, бүлгийн эрх ч байна уу хуваагдашгүй, бие биенээсээ хамаарч байдаг.

Ялгаварлан гадуурхахгүй, тэгш байх

Ялгаварлан гадуурхахгүй, тэгш байх зарчим нь олон улсын хүний эрхийн хуулинд нэвт шингэсэн, тэгш байх зарчим нь ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг төгс болгож баталгаажуулдаг

Эрх ба үүрэг

Хүний эрх нь эрх, үүрэг аль алиныг үүсгэдэг. Засгийн газар: хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах, хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Хувь хүмүүс: хүний эрхээ эдлэх эрхтэй боловч бусдын эрхийг хүндэтгэх үүрэг хүлээдэг.

## Хүний эрхийн ангилал

Хүний эрхийн ангилал				
<b>Иргэний эрх:</b> <i>амьд явах, хөгжих, шашин шүтэх, гэрлэх, үр удмаа үлдээх, аюулгүй орчин, өлсгөлөнгөөс ангид байх, усаар хангагдах, ...</i>	<b>Эдийн засгийн эрх:</b> <i>хоол хүнс, хувцас, орон байр хүрэлцэхүйц орлоготой байх, хөдөлмөрлөх, ажил хаях, өмчлөх, өв залгамжлуулах ...</i>	<b>Улс төрийн эрх:</b> <i>үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, сонгох сонгогдох, эвлэлдэн нэгдэх, оролцох, жагсаал хийх, гомдол гаргах, ...</i>	<b>Нийгмийн эрх:</b> <i>Амрах, эрүүл мэндийн үйлчилгээ авах, Сурах, аялах, хөдөлмөрийн таатай нөхцлөөр хангагдах.....</i>	<b>Соёлын эрх:</b> <i>бүтээл туурвих, хэвлэн нийтлэх, уламжлалт соёлоо өвлөх, хадгалах, урлагийн бүтээл туурвих, ШУ-ы нээлт хийх...</i>

Иргэн бүрийн хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах, хэрэгжүүлэх үүргийг Засгийн газар НҮБ-ын хүний эрхийн олон гэрээ, конвенциор хүлээдэг. Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний жагсаалтыг хавсралт 1-ээс харна уу. Эдгээр конвенци, гэрээний хэрэгжилтээр Засгийн газраас тогтмол тайлан илгээдэг. Засгийн газрын тайлангийн зэрэгцээ төрийн бус байгуулагуудаас сүүдэр илтгэл илгээдэг ба гэрээний нэмэлт протоколын дагуу хувь хүмүүс өргөдөл, гомдол илгээх боломжтой.

## Хүний эрхийг хамгаалах нь хүний эрх юм.

Хүний эрхийн хамгаалагч дараах эрхийг эдэлнэ.

<p>Хүний эрхийг өөрийн улсад болон дэлхий дахинд хөхиүүлэн дэмжих</p> 	<p>Ганцаар болон бусадтай нийлэн хүний эрхийг хамгаалах</p> 	<p>Холбоо, төрийн бус байгууллага байгуулах</p> 
<p>Албан тушаалтны үйл ажиллагааг шүүмжлэх, сайжруулах санал гаргах, хүний эрхийн хэрэгжилтэнд саад болох аливаа аюул, эрсдэлийн тухай анхааруулах</p> 	<p>Хүний эрхтэй холбоотой төр засгийн бодлого, үйл ажиллагааны тухай гомдол гаргах, хянуулах</p> 	<p>Хүний эрхийг хамгаалахад мэргэжлийн түвшинд чанартай хуулийн зөвлөгөө, тусламж санал болгох, үзүүлэх</p> 
<p>Хүний эрхтэй холбоотой мэдээлэл хайх, олж авах, хадгалах</p> 	<p>Хүний эрхийн шинэ санаа, зарчмыг боловсруулах, хэлэлцүүлэх, хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө ажиллах</p> 	<p>Хүний эрхийн хамгаалагчийн мэргэжил, ажлыг хуулийн дагуу эрхлэх</p> 
<p>Тайван уулзалт, цуглаан зохион байгуулах, оролцох</p> 	<p>Хүний эрхийг хамгаалах зорилгоор хөрөнгө, нөөц дайчлах, цуглуулах, зарцуулах</p> 	<p>Ямар нэг хязгаарлалтгүйгээр төрийн бус болон засгийн газар хоорондын байгууллагуудтай харьцах</p> 
<p>Нийтийн сонгол, шүүх хурал зэрэгт сууж олон улсын хүний эрхийн үүрэг, үндэсний хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг үнэлэх</p> 	<p>Гомдол, хохирлоо барагдуулах, үр шимийг хүртэх</p> 	



## ***Хүний эрхийн хамгаалагч гэж хэн бэ?***

Хэн ч хүний эрхийн хамгаалагч байж болно. Өөрөөр хэлбэл эрэгтэй, эмэгтэй хэн ч хаана амьдардаг (хот, хөдөө), хэдэн настай (ахмад, өсвөр), нийгэмд эзлэх байр суурь, мэргэжил, цөөнхөд (үндэстэн, бэлгийн) хамаарахаас үл шалтгаалан хүний эрхийн хамгаалагч байж болно. Хүний эрхийн хамгаалагч нь хүний эрхийг өөрийн улсад болон дэлхий дахинд хөхиүлэн дэмжих, ганцаар болон бусадтай нийлэн хүний эрхийг хамгаалах, үүний тулд холбоо, төрийн бус байгууллага байгуулах, тайван уулзалт, цуглаан зохион байгуулах, оролцох, хүний эрхтэй холбоотой мэдээлэл хайх, олж авах, хадгалах эрхтэй.

Энэхүү үйлдлийг тэд ганцаар эсхүл аль нэг байгууллагад нэгдэн хийдэг байна. Гагцхүү хүний эрхийг хамгаалах үйдлийг тайван замаар, хүчирхийллийн бус аргаар хийх ёстой.

## Хүний эрхийн хамгаалагч



Байгаль орчны  
тэмцэгч



Малчин



Үйлдвэрчний эвлэл



Хүний эрхийн  
хуульч



Сэтгүүлч



Эрдэмтэд



Оюутан тэмцэгч

Хүний эрхийн хамгаалагчид хүний эрхийн янз бүрийн асуудал, тухайлбал амьд явах, хоол хүнсээр хангагдах, эрүүл мэндийн үйлчилгээ авах, шаардлага хангасан орон сууцаар хангагдах, нэр ба иргэншилтэй байх, боловсрол эзэмших, чөлөөтэй зорчих, ялгаварлан гадуурхлаас ангид байх эрхийн төлөө тэмцдэг. Эмэгтэйчүүд, хүүхэд, уугуул иргэд, дүрвэгсэд болон дотооддоо шилжин суурьшсан хүмүүс зэрэг нийгмийн янз бүрийн бүлгийн эрх, тэрчлэн үндэстний болон хэлний, бэлгийн цөөнхийн эрхийг хамгаалан ажилладаг.

Хүний эрхийн хамгаалагчдын тухай тунхаглалд “хүний эрхийн хамгаалагч гэж хувь хүн хийгээд нийтийн хүний эрх, үндсэн эрх чөлөөг зөрчиж буй бүхий л хэлбэрийг арилгахын тулд үр дүнтэй ажиллаж, хувь нэмэр оруулж буй хувь хүн, хэсэг бүлэг, нийгэмлэг холбоодыг хэлнэ” хэмээн заасан байдаг.

## ***Хүний эрхийн хамгаалагч юу хийдэг вэ?***

- Хүний эрхийн зөрчлийг баримтжуулж, мониторинг хийдэг;
- Олон нийтэд мэдлэг, ойлголт түгээдэг;
- Төрийн байгууллагуудтай хамтран ажилладаг;
- Жагсаал, цуглаан зохион байгуулах, гар биеэр оролцох;
- Хохирогчдод хууль зүйн туслалцаа үзүүлнэ;
- Кампанит ажил өрнүүлэх;
- Хохирогчид болон нийгмээс гадуурхагдсан хүмүүсийг чадавхжуулах, сургах ... гэх мэт.

## Хоёр: Хүний эрхийн хамгаалагчид тулгардаг эрсдэл, түүний хэлбэр

Хүний эрхийн хамгаалагч эмэгтэйчүүд нь эмэгтэй учраас илүү эрсдэлд ордог. Мөн эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалж буй эрэгтэйчүүд ч эрсдэлд орох нь түгээмэл байдаг. Эмэгтэй хүний эрхийн хамгаалагчдад тулгардаг эрсдэл нь илүү өргөн хүрээтэй. Учир нь эрсдэлийн ноцтой хэлбэр болох бие мах бодын болон бэлгийн хүчирхийллээр илрэх тохиолдол байдаг.



Монгол улсын нөхцөлд байгаль хамгаалагчид, орон нутгийн иргэд, авилгын эсрэг бичдэг сэтгүүлчид илүү эрсдэлтэй байдаг байна. Одоогоор Монгол улсад хүний эрхийг хамгаалах үйлдлийг хөхиүлэн дэмжих, хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах эрх зүйн болон бүтцийн зохистой орчин бүрдээгүй. Иймээс хүний эрхийн хамгаалагчид ажил үүргээ гүйцэтгэж явахдаа төрөл бүрийн саад бэрхшээлтэй тулгарч, эрсдэлд өртдөг. Одоогоор илэрч байгаа эрсдэлийн хэлбэрүүдийг доор дурьдлаа.

**Амь насаа алдах:** Байгаль хамгаалагчид болон сэтгүүлчид халдлагад өртөж гэмтэх, амь насаа алдах тохиолдол гарах болсон. Ийм тохиолдолд цагдаагийн байгууллагаас шуурхай, хууль ёсны үйл ажиллагаа явуулж байгаад олон нийт итгэхгүй болсон.

*Кэйс 1: Ирвэс хамгаалах сангийн биологич 27 настай Т.Лхагвасүмбэрэл 2015.11 сард Улаанбаатар хот дахь гэрээсээ гараад сураггүй болж 6 хоносны дараа Хөвсгөл далайн эрэг дээр (УБ хотоос 850 орчим км зайд) амь насаа алдсан байдалтай олдсон юм. Тэрээр ашигт малтмалын томоохон нөөцтэй ордууд бүхий Өмнөговь аймгийн Тост, Тосонбумбын нуруунд цоохор ирвэс хамгаалахад сэтгэл зүрхээ зориулан ажилладаг байгаль хамгаалагч залуу байсан. Энэ хэрэгт цагдаагийн байгууллагаас мөрдөн байцаах ажиллагаа хийж, үхлийн шалтгааныг амиа хорлон живж үхсэн гэсэн дүгнэлт хийсэн. Харин хамтран ажиллагсад болон орон нутгийн иргэд түүний үхлийн шалтгааныг уул уурхайн компаний үйл ажиллагааг эсэргүүцсэнтэй холбоотой байж болзошгүй гэж үздэг бөгөөд үүнийг дэмжих нотолгоо олон нийтэд ил болсон юм. Түүнчлэн золгүй явдлын өмнө талийгаач хэд хэдэн удаа үл мэдэх хүмүүсийн халдлагад өртөж байсан боловч тухай бүр орон нутгийн цагдаагийн байгууллагаас шаардлагатай арга хэмжээг аваагүй гэдэг.*

*Кэйс 2: Уул уурхайн үйл явдал, мэдээ, мэдээллийг эрэн сурвалжлан бичдэг "Монголын уул уурхайн сэтгүүл"-ийн үүсгэн байгуулагч, эрхлэгч Л.Болормаа 2015.11 сард өөрийн гэртээ толгойн ар хэсэг буюу дагзандаа хүнд гэмтэл авснаас болж нас барсан. Тэрбээр амьдралынхаа сүүлийн 10 жилд улс төр, эдийн засгийн ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүсийн талаар олон нийтлэл бичсэн билээ. Түүний үхлийн шалтгааныг гадны нөлөөгүй гэсэн дүгнэлт гарсан. Гэвч олон нийтэд ил болсон хэргийн нөхцөл байдлын мэдээлэл, түүний эрхэлж байсан үйл ажиллагаатай холбоотойгоор уг дүгнэлтийг олон нийт болон сэтгүүлчдийн эрхийг хамгаалах Глоб интернэшнл төв зэрэг байгууллагууд эсэргүүцсэн.*

**Барьцаалагдах:** Хүний эрхийн хамгаалагчдыг үл таних хүмүүс эсвэл зарим тохиолдолд хүчний байгууллагынхан хүчээр саатуулах, баривчлах, хорих, урт буюу богино хугацаагаар барьцаалах, барьцаанд байлгах хугацаандаа зодож нүдэх явдал тохиолддог.

*Кэйс 3: Монголын чөлөөт ахмадуудын холбооны тэргүүн ахмадын эрхийн төлөө дуу хоолойгоо хүргэж, жагсаал цуглаан хийж байсан. Энэ үйл ажиллагаанаас нь болж түүнийг 8 удаа баривчилан саатуулж, сүрдүүлж байжээ.*

**Дарамтлах, сүрдүүлэх:** Хүний эрхийн хамгаалагчдыг сүрдүүлэх тохиолдол түгээмэл бөгөөд ихэнх тохиолдолд мэдэгдэлгүй өнгөрдөг гэж үздэг.

*Кэйс 4: Дорноговь аймгийн Улаанбадрах сумын иргэд цацраг идэвхит бодис ураны хайгуул, олборлолт хийж буй Кожеговь компаний үйл ажиллагаанаас орон нутагт учирч буй сөрөг нөлөөллийг эсэргүүцэн, уурхайн үйл ажиллагааг зогсоох зорилгоор орон нутгийн захиргаа, Засгийн газар, УИХ-д хандаад ямар ч амжилт олоогүй юм. Иймээс орон нутгийн иргэд эд хөрөнгө, эрүүл мэнд, сэтгэл санаагаараа хохирч байгаа тул үйл ажиллагаагаа зогсоохыг шаардаж уурхайн дэргэд жагсахад, жагсаалд оролцсон нэг иргэнийг ажлаас нь хална гэж сүрдүүлж, тэдгээрийн хийж буй үйл ажиллагааг хууль бус гэж хүчээр тарааж, зодож, цагдаагийн байгууллагаас гол зохион байгуулсан гэх хүмүүсийг баривчилж байсан тохиолдол удаа дараалан гарсан байна.*

**Тагнах, чагнах:** Хүний эрхийн хамгаалагчдын араас тагнаж, утасны шугамыг нь таслах буюу нууцаар чагнадаг байна.

*Кэйс 5: Ураны хайгуул, олборлолт, уурхайн үйл ажиллагааны чиглэлээр ажилладаг, чөлөөт сэтгүүлчийг олон жилийн туршид утсыг нь чагнаж тагнадаг бөгөөд түүний зорилтот бүлгийн иргэдтэй хийхээр төлөвлөсөн ажлыг нь нураах тохиолдол удаа дараа гарч байсан.*

**Хэвлэн нийтлэх эрх чөлөөг хорих:** УИХ-ын үйл ажиллагааг сурвалжлах сэтгүүлчийн УИХ-ын гишүүдийн чуулганы хуралдаа суухгүй байх, хурал дээрээ ирээд кэнди краш тоглох, хоорондоо зодолдох, үгсэн хуйвалдах зэрэг үйлдлийг хэвлэн нийтэлсний төлөө сэтгүүлчийн үнэмлэхийг нь удаа дараа хураасан байдаг.

## Гурав: Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах нь

### *Хүний эрхийн хамгаалагчийн тунхаглал*

Хүний эрхийг хамгаалах нь өөрөө нэг эрх бөгөөд үүнийг эдлэхэд хүний эрхийн хамгаалагчдад маш их эрсдэл учирч байгаа учраас хүний эрхийг хамгаалан ажилладаг хүмүүсийг хамгаалах учиртай гэдгийг хүлээн зөвшөөрч НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1998 оны 12 дугаар сарын 9-ний өдөр “Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн Тунхаглал”-ыг баталжээ.



## Хүний эрхийн хамгаалагчийн эрхийн талаарх Тунхаглалын ач холбогдол

- Хүний эрхийг хамгаалагчийн үүргийг онцолж, тодорхойлсон

- Хүний эрхийг хамгаалагчдын эрх, хамгаалалтын талаарх төрийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон

- Зөвхөн төрөөр хязгаарлахгүй – хүн бүрийн үүргийг тодорхойлсон.

- Олон баримт бичигт туссан эрхийг нэгтгэн, бодит нөхцөл байдалд хэрэглэж болохуйцаар боловсруулсан.

- Зарим эрхийг бусад баримт бичигт байдгаас илүү оновчтой, нарийвчлан тодорхойлсон.

- Улс орнууд тунхаглалыг заавал биелүүлэх үүрэг хүлээдэггүй боловч Ерөнхий Ассамблейн тогтоолоор соёрхон баталсан тул ёс суртахууны ач холбогдолтой

Эрх зүйн хувьд “тунхаглал” гэдэг нь гишүүн орнууд заавал биелүүлэх үүрэг хүлээдэггүй боловч олон улсын хүний эрхийн гэрээ конвенцид заасан хүний эрхийн стандартыг агуулсан байдаг тул зайлшгүй хэрэгжүүлэх үүргийг агуулна. Жишээ нь, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад тодорхойлсон хүний эрхийн стандартуудыг тус пактыг соёрхон баталсан улсууд дотоодын хуулиндаа нутагшуулж, мөрдүүлэх ёстой бөгөөд тунхаглал нь пактын стандартыг агуулсан учраас зайлшгүй хэрэгжүүлэх үндэслэл болно. Иймээс Монгол Улс ИУЭП-д нэгдсэн улс учраас тунхаглалыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүний нэгэн адил тунхаглал нь хүний эрхийн олон улсын бусад гэрээ конвенцийн холбогдох стандартыг агуулан хэрэгжинэ.

### **Тунхаглалын үндэслэл:**

**// Тунхаглал нь хүний эрхийг батлан хамгаалах, хангах үүрэг, хариуцлага хүлээлгэдэг олон улсын хуулиудад үндэслэх ба тэдний үзэл санааг нэгтгэн илэрхийлнэ. //**

### **Хүний эрхийн хамгаалагчдын тусгай илтгэгч**

НҮБ-ын Хүний эрхийн Комисс нь 1998 онд гаргасан Хүний эрхийн хамгаалагчийн тухай тунхаглалыг хэрэгжүүлэх үүднээс 2000 онд хүний эрхийн хамгаалагчдын асуудал эрхэлсэн бүрэн эрхтэй Тусгай төлөөлөгчийг томилсон нь тунхаглалын хүрээнд хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах олон улсын анхны механизм болжээ. Хүний эрхийн Зөвлөл нь 2008 онд НҮБ хүний эрхийн хамгаалагчдын Тусгай төлөөлөгчийг “Тусгай илтгэгч” болгон өөрчилсөн бөгөөд Тусгай илтгэгч (ТИ) нь ямар ч улсаас хараат бусаар ажилладаг.

### Тусгай илтгэгчийн эрх:

1. Хүний эрхийн хамгаалагчдын нөхцөл байдлын талаар мэдээлэл хайх, хүлээн авах, шалгах, хариу өгөх
2. Тунхаглалын хэрэгжилтийг сайжруулах үүднээс улс орнуудын засгийн газар болон бусад байгууллагуудтай яриа хэлэлцээр хийх, хамтран ажиллах
3. Хүний эрхийн хамгаалагчдын талаар баримтлах үр дүнтэй стратеги боловсруулах, сайжруулах талаар зөвлөмж өгч гүйцэтгэлд нь хяналт тавих

*Тусгай илтгэгч хүний эрхийн хамгаалагчдын эрхийг зөрчсөн аль нэг хэргийг онцгойлон авч үзэж болох бөгөөд уг хэргийн талаарх мэдээллийг төрөл бүрийн эх сурвалжаас авах эрхтэй.*

**Жишээ нь:** Ямар ч мэдээллийг төрийн байгууллага, төрийн бус байгууллага, НҮБ болон НҮБ-ын харьяа байгууллагууд, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээс авахаас гадна хүний эрхийн хамгаалагч хувь хүнээс ч мэдээлэл авч болно. Мэдээллийн дагуу Тусгай илтгэгч ХЭХ-чдын эрх зөрчигдсөн улсын засгийн газарт уг асуудлыг судлах, хянан шийдвэрлэх, шалгах талаар мэдэгдэл явуулдаг. Хэрэв тухайн цаг үед хүний эрхийн зөрчлүүд гарч байвал тэдгээрийг зогсоох, эсвэл урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг хүссэн шуурхай захидал явуулдаг. Тусгай илтгэгчийн өөр нэг бүрэн эрх нь аливаа улс орнуудад албан айлчлал хийж тухайн нөхцөл байдалтай нь дэлгэрэнгүй танилцаж, илрүүлсэн асуудал дээр шийдэж болох арга замын талаар зөвлөмж өгдөг. Тусгай илтгэгчийн албан айлчлал нь 5-10 хоног үргэлжилдэг бөгөөд айлчлалын үеэр төр засгийн удирдлагууд, холбогдох сайд нар, хараат бус хүний эрхийн байгууллагууд, НҮБ-ын байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон хүний эрхийн хамгаалагч нартай биечлэн уулздаг. Энэ нь тус улсын хүний эрхийн хамгаалагчдын нөхцөл байдалд бодитой үнэлгээ хийж, цаашид тухайн материал дээр үндэслэн хамгаалагчдыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа явуулна гэсэн үг юм.

Хүний эрхийн хамгаалагч эрсдэлд өртсөн тохиолдолд баримтжуулан Тусгай илтгэгчид мэдээлж болох ба мэдээллийг тусгай маягтад оруулан илгээнэ. Уг тусгай маягыг авах, мэдээллээ бөглөх тохиолдолд ХЭХТ-тэй холбогдож, аргазүйн дэмжлэг авах боломжтой.

## Үндэсний хууль тогтоомж, бүтэц тогтолцоо

Хүний эрхийн зөрчлийг эсэргүүцэн  
тайван үйл ажиллагаа явуулахдаа  
үндэсний хууль тогтоомжоор  
хамгаалуулах



Хүний эрхийн хамгаалагчдын эдлэх эрх нь тэдний хамгаалалт юм. ХЭХ-чдыг төр үндэсний хууль тогтоомжоор хамгаалах үүрэгтэй. Түүнчлэн Хүний эрхийн үндэсний комисс нь үйл ажиллагааныхаа хүрээнд, үндэсний ТББ-ууд нь ХЭХ-чдыг хамгаалах, эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чадавхижуулах, дэмжлэг үзүүлэх

чухал үүрэгтэй оролцогч талууд юм.

Хүний эрхийн хамгаалагчид нь эрсдлээс урьдчилан сэргийлэх, өөрсдийгөө хамгаалахад суралцах зайлшгүй шаардлагатай бөгөөд ганц ганцаараа ажиллах нь илүү их эрсдэл дагуулдаг тул тухайн орон нутагт хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ, бүлгүүдтэй хамтран ажиллах нь тэдэнд тулгарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад маш чухал ач холбогдолтой юм.


Монгол Улсад хүний эрхийн хамгаалагчдын үндэсний зөвлөлдөх уулзалтыг ФОРУМ-АЗИ, гишүүн байгууллага ХЭХТ хамтран 2015 оноос эхлэн жил дараалан 4 удаа зохион байгуулж давхардсан тоогоор нийт 200 гаруй ХЭХ-чийг оролцуулсан. Тэднийг ХЭХ-чийн сүлжээнд бүртгэн нүүр хуудас нээж холбож ажилладаг. Тэдний байршилыг доорх зургаас харна уу.

Сүлжээний хүрээнд хүний эрхийг хамгаалах үйлдэлдээ ямар нэг эрсдэлд орсон бол баримтжуулах маягтыг бөглөж Хүний эрх хөгжил Төвд илгээнэ үү. Маягтыг хавсаргав.

Маягтыг хүлээж аваад шаардлагатай тохиолдолд ХЭХ-чийг хамгаалахад шаардлагатай нүүлгэн шилжүүлэх, эрүүл мэнд, хуулийн зөвлөгөө зэрэг үйлчилгээ үзүүлэх тусламжийг ФОРУМ-АЗИ олон улсын хүний эрхийн байгууллагатай холбон үзүүлнэ.

# ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫН СҮЛЖЭЭ

/аймаг, сумдаар/



- ★ I зөвлөлгөөний оролцогчид
- ★ II зөвлөлгөөний оролцогчид
- ★ III зөвлөлгөөний оролцогчид
- ★ IV зөвлөлгөөний оролцогчид

## Дөрөв: Хүний эрхийн хамгаалагчдад өгөх зөвлөмж

Хүний эрхийн хамгаалагчдыг өртөх эрсдлээс хамгаалах, урьдчилан сэргийлэхийн тулд Та дараахь асуудлыг анхаарч ажиллахыг зөвлөмж болгож байна. Үүнд:


- ⇒ Эрсдэлд хүргэж болзошгүй нөхцөл байдлын талаар мэддэг байж, түүнийг арилгах, нөлөөг бууруулах зохицуулалтыг хийх.
- ⇒ Аль болох эрсдэлгүй байдлаар ажлаа төлөвлөх, өөрийгөө болон хамтран ажиллаж байгаа хүнээ аюулд оруулахгүй байх талаас нь анхаарах
- ⇒ Эрсдэлтэй газар явж ажиллахаар бол энэ тухайгаа хамтран ажиллагсаддаа хэлэх, утасны дугаараа үлдээх, тодорхой хугацааны дараа холбоо барихаар тохиролцох
- ⇒ Шүгэл, дуут дохио гаргах хэрэгслийг биедээ авч явах, эрсдэлд орсон үед түүнийгээ дуугаргаж хүмүүсийн анхаарлыг татах
- ⇒ Тусгай хамгаалалттай (нохой, хамгаалах албатай зэрэг) газарт ажиллахдаа гэнэтийн дайралтаас сэргийлэх хэрэгсэл авч явах(мод, чулуу гэхдээ бусдын амь насанд айтгар хохирол учруулахааргүй)
- ⇒ Эрсдэлтэй нөхцөл байдалд ажиллахдаа бусдад ил харагдахаар ажиллахыг хичээх, ганцаараа эрсдэлт газар луу явахгүй байх, хэн нэгэнтэй заавал хамт явах
- ⇒ Эрсдэлт нөхцөл байдлын асуудлаар илэн далангүй хамтрагчиддаа хэлэх, аливаа сэтгэл түгшээсэн асуудлыг ил гаргаж дэвшүүлэх, ярилцах
- ⇒ Эрсдэлт газар луу явахын өмнө Хүний эрхийн байгууллагуудаас зөвлөгөө авах, зөвлөгөө авах боломжгүй үед явахаа хойшлуулах

**Хүний эрхийн хамгаалагч Та эрсдлээс өөрийгөө  
болон бусдыг хамгаалаарай !**

## Яаралтай, эрсдэлтэй нөхцөл байдалд холбоо барих байгууллагуудын мэдээлэл

### Хүний эрхийн үндэсний комисс

Хүний эрхийг хамгаалагч нь төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль"-д тодорхойлсны дагуу төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь иргэдийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг зөрчсөн тохиолдолд энэхүү зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комист хандаж гомдол гаргаж болно. ХЭҮК нь 21 аймагт хүний эрхийн референтүүдтэй тул иргэд өөрсдийн орон нутагт байх хүний эрхийн референтүүдтэй холбогдож, гомдлоо гаргаж болно.



<b>Улаанбаатар хот дахь ХЭҮК</b>	Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын XI байр, V давхар Өргөдөл, гомдол хүлээн авах, хууль зүйн зөвлөгөө өгөх утас: 70 000 222, 51-262971, 51-262786 Цахим хуудас: <a href="http://www.mn-nhrc.org">www.mn-nhrc.org</a> Цахим шуудан: <a href="mailto:info@mn-nhrc.org">info@mn-nhrc.org</a> Facebook хуудас: <a href="http://www.facebook.com/nhrcom">www.facebook.com/nhrcom</a>
<b>Хүний эрх хөгжил төв</b>	Улаанбаатар хот-15172, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-54, Пийс тауэр 11 давхар, 1103 тоот Утас: (976)11-325721, (976)11-319037 Факс: (976)11-325721 Вэб: <a href="http://www.chrd.org.mn">http://www.chrd.org.mn</a> Имейл: <a href="mailto:chrd@mongolnet.mn">chrd@mongolnet.mn</a>
<b>ФОРУМ-АЗИ</b>	бүсийн байгууллагын хүний эрхийн хамгааллын хөтөлбөртэй холбогдох бол Монгол улс дахь гишүүн байгууллагуудын нэг Хүний эрх хөгжил төвд хандана уу.
<b>Монголын эмэгтэйчүүдийн сан</b>	Улаанбаатар хот, СБД, Бага тойруу 48-р байр 305 тоот ш/х-280 46А салбар Утас: (976) 7711 9991 Вэб: <a href="http://mongolianwomensfund.mn">mongolianwomensfund.mn</a> Имэйл: <a href="mailto:info@mones.org.mn">info@mones.org.mn</a>



## ***Хавсралт 1. Монгол Улсын соёрхон баталсан олон улсын хүний эрхийн гэрээ конвенцууд***

- Иргэний, улс төрийн эрхийн олон улсын пакт;
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт;
- Арьс үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц;
- Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц;
- Цагаач ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай конвенц;
- Хүүхдийн эрхийн тухай конвенц;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенц;

**Хавсралт 2.****ХЭХ-чийн тухай Ерөнхий мэдээлэл**

1.	Овог:
2.	Нэр:
3.	Нас:
4.	Хүйс:
5.	Мэргэжил:
6.	Холбоо барих утас:
7.	Хаяг:
8.	Таны анхаарч ажилладаг хүний эрхийн асуудал:

**Хүний эрхийн хамгаалагчид тулгардаг бэрхшээл, хүндрэл, эрсдэл**

9.	Та ямар асуудал хөндөж гаргасан бэ?
10.	Таны хүний эрхийг хамгаалах үйлсэд ямар сөрөг үйлдэл, дарамт, шахалт зэрэг эрсдэл учруулав?
11.	Та үүнд ямар хариу үйлдэл үзүүлсэн бэ? Үр дүн гарсан уу?
12.	Одоо ямар тусламж хэрэгтэй байна вэ?

**Хүний эрхийн хамгаалагчийн эсрэг хүчирхийлэл үйлдэгчийн тухай мэдээлэл**

13.	Танд учруулсан эрсдэлийг үйлдсэн этгээдийн албан тушаал, ажлын газар болон хэзээ, хаана, ямар үйлдэл таны эсрэг хийсэн тухай бичнэ үү.
14.	Дээрх этгээдийн тухай мэдээлэл:

Нэр:

хаяг:

Албан ёсны цахим хуудас:

**Мэдээлэл өгсөн: (Хувь хүний мэдээллийг нууцыг хадгална)**

Нэр:

Гарын үсэг:

Он/сар/өдөр:





СБД, 6-р хороо, Бага тойруу  
48-р байр, 305 тоот  
Улаанбаатар-46А, Ш/Х 280  
Улаанбаатар, Монгол

